


**ЖАРГАЛАНТ СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**


2025.12.03


Жаргалант сум

ЗОРИЛГО: Жаргалант сумын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх шалтгаан нөхцөл, хүчин зүйлсийг тогтоон арилгах зэрэг чиглэлээр зохих хууль хяналтын болон бусад байгууллагуудын оролцоо, гүйцэтгэх үүрэг, зохион байгуулалтын арга хэмжээг тодорхойлж, хамтын ажиллагааг уялдуулж гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад оршино.

Д/Д	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хамтран Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн түвшин	Биелэлт
НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АСУУДЛЫН ХҮРЭЭНД						
1.1	Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, зөвлөлөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, тайлангаа хагас, бүтэн жилээр гарган тайлагнах	Жилдээ	Сумын ГХУСАЗС3-ийн дарга	Сумын ГХУСАЗС3-ийн гишүүд	Сумын ГХУСАЗС3-ийн хуралдааныг тогтмол явуулж, үйл ажиллагааг хагас бүтэн жилээр дүгнэсэн байна.	Сумын ГХУСАЗС3 нь 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр 14 цагт ЗДТГ-ын хурлын зааланд 100 хувийн ирцтэйгээр хуралдаж 4 бүлэг 36 ажлыг хийхээр төлөвлөж тухайн жилийн төлөвлөгөөг баталж 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр хуралдаж хагас жилийн тайланг хэлэлцсэн. Хагас жилийн байдлаар нийт 36 ажлаас 20 ажил хийгдэж 56.7 хувийн гүйцэтгэлтэй байсан. ГХУСАЗС3-ийн бүтэн жилийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хуралдахаар төлөвлөн ажиллаж байна.
1.2	Гэмт хэрэг, зөрчлөөс	Жилдээ	Сумын ГХУСАЗС3-	Сумын ГХУСАЗС3-	Холбогдох журмын дагуу	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, зохих үр дүн

	урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, зохих үр дүн гаргасан байгууллага, албан хаагч, иргэнийг шагнаж, урамшуулах ажлыг зохион байгуулах		ийн дарга	ийн гишүүд	шагнал, урамшууллыг болзол, шаардлагын дагуу олгосон байна.	<p>гаргасан төрийн албан хаагч 3, ААН-ийн 3 иргэнийг Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн шагналаар шагнуулсан.</p> 
1.3	Багийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулж сургалт сурталчилгааг тогтмол явуулах	Улирал бүр	Цагдаагийн хэсэг, 3 багийн ажлын алба, БИНХ	Холбогдох бусад байгууллага, албан хаагчид	Иргэдийн хуулийн мэдлэг дээшилж, гэмт хэрэг, зөрчилд холбогдох хүний тоо буурсан байна.	<p>Жаргалант баг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдаж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан 5 иргэнд зөрчлийн тухай хуулийг танилцуулж нийтийн хог цэвэрлэгээнд хамруулсан.</p> <p>Дулаан-Уул баг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдаж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан 3 иргэнд зөрчлийн тухай хуулийг танилцуулж нийтийн хог цэвэрлэгээнд хамруулсан байна.</p> <p>Хил залгаа аймаг сумдын хулгайн мал, мах тээвэрлэж болзошгүй зам маршрутыг зурагжуулан гаргасан. Сумын цагдаагийн хэсэгт багийн малчдаас гэмт хэргийн шинжтэй дуудлага ирснийг цаг тухайд нь хамтран үзлэг</p>

						шалгалтыг зохион байгуулж арга хэмжээ авч ажилласан. Сумын цагдаагийн хэсгийн гаргасан маршрутын дагуу хамтран эргүүл шалгалтыг хийж малчид иргэдээс нэргүй санал хүсэлтийг авч цагдаагийн хэсгийн алба хаагч нар нэргүй саналаар гарсан иргэдийг шалгаж ажилласан.
1.4	ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааг иргэд, аж ахуйн нэгжүүдэд сурталчлах ажлыг зохион байгуулах	Жилдээ	3 багийн ажлын алба, БИНХ	Холбогдох бусад байгууллага, албан хаагчид	Сумын ГХУСАЗСЗ-ийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.	<p>Сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн №11 дугаар удирдамжийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл үүсэж байгуулагдсаны 60 жилийн ойг угтаж Орхон аймгийн ГХУСАЗСЗ-өөс зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээнд сумын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааг иргэд, ААНБ-дад сурталчлан таниулах үйл ажиллагаа зохион байгуулан оролцсон.</p> 

						
1.5	Хөрш зэргэлдээ сумуудтай туршлага судалж, хамтран ажиллах	II улиралд	ГХУСАЗСЗ-ын дарга	ГХУСАЗСЗ-ын гишүүд	Хөрш зэргэлдээ сумдтай хамтын ажиллагаа сайжирсан байна.	Сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн №15 дугаар удирдамжийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Булган аймгийн Хангал сумын ГХУСАЗСЗ-ийн 9 гишүүн, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ГХУСАЗСЗ-ийн 11 гишүүн, Жаргалант сумын ГХУСАЗСЗ-ийн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй туршлага судлах, санамж бичигт гарын үсэг зурах, нөхөрсөг гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулсан.

--	--	--	--	--	--






1.6	Сумын хэмжээнд эргүүл шалгалтын ажлыг тогтмол зохион байгуулах	Сар бүр	Цагдаагийн хэсэг	Холбогдох бусад байгууллагууд	Сумын хэмжээнд гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлнэ.	<p>Сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар удирдамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сараас 2025 оны 12 дугаар сарын 02-ны байдлаар суманд нийт 209 удаагийн эргүүл шалгалтыг хийж ажилласан. Давтагдсан тоогоор 13,000 иргэнийг шалгаж, 3826 хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг болон бусад зөрчлийг илрүүлж, давтан гаргахаас урьдчилан сэргийлж 3826 зөрчил гаргасан иргэнд холбогдох хуулийн дагуу 114,000.000 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.</p>  
-----	--	---------	------------------	-------------------------------	---	---

						 
ХОЁР.ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД						
2.1 Архидан согтуурах, мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд						
2.1. 1	Сумын хэмжээнд архинд донтож болзошгүй иргэдийн судалгааг гаргаж, сайн дурын	Жилдээ	Цагдаагийн хэсэг	Багийн ажлын алба Нийгмийн ажилтан	Архины хамааралтай иргэдийн тоо буурсан байна.	Архины хамааралтай 11 өрхийн 14 иргэний судалгааг гаргаж, архины хамааралтай 5 иргэнийг албадан эмчилгээнд хамруулж нийгэмшүүлэх сургалт болон шаардлагатай бусад тусламж дэмжлэгийг хүргэж ажилласан.


эмчилгээнд
хамруулах
ажлыг зохион
байгуулах



2.1. 2	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг аж ахуйн нэгж, байгууллагууда Д сурталчлан таниулах	II улиралд	Цагдаагийн хэсэг	Багийн ажлын алба	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	<p>Жаргалант суманд үйл ажиллагаа явуулдаг архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг 10 аж ахуйн нэгж, иргэнд 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчлан таниулах сургалтыг орж, хяналт шалгалтыг тогтмол хийж зөвлөмж, зөвлөгөөг өгч, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн иргэн болон 21 насанд хүрээгүй иргэнд архи согтууруулах ундаа худалдаалахгүй байх, тогтоосон цагийн хуваарийн дагуу үйл ажиллагааг явуулах талаар тогтмол зөвлөгөө өгч ажиллаж байна.</p> 
-----------	---	---------------	------------------	-------------------	---	--

						 
2.1. 3	Электрон болон утаат тамхины хор хөнөөлийн талаар сургалт нөлөөллийн үйл ажиллагааг	II улиралд	Хамтарсан баг	Цагдаагийн хэсэг, ЕБС, ЭМТ,	Электрон болон утаат тамхины хэрэглээ багасаж, иргэд мэдээ мэдээлэлтэй	Цагдаагийн хэсгээс Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан Г.Урангоогийн хамт Жаргалант сумын ЕБС-ийн ахлах, дунд ангийн сурагчдад “Хорт зуршил түүний хор нөлөө” сэдэвт сургалтыг ахлах дунд ангийн нийт 120

	<p>зохион байгуулах</p>				<p>болно.</p>	<p>сурагчдыг хамруулан зохион явуулж, байгууллага аж ахуй нэгж иргэдэд сурталчилсан бөгөөд сумын ерөнхий боловсролын сургууль нь утаат болон электрон тамхи татдаг, татаж болзошгүй сурагчдын судалгааг гарган, “Электрон тамхины хор уршиг эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөө” үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган сургуулийн цахим хуудсанд утаат болон электрон тамхины хор хөнөөлийн сурталчилгааг хийн байршуулж , Хүүхдийн оролцооны байгууллын “Өсвөрийн эмч” клубын сурагчид дэлхийн сэтгэцийн эрүүл мэндийн өдрөөр тамхины хор уршгийн талаар контент хийж байршуулан сурагчдад түгээн дэлгэрүүлж ажилласан.</p> 
--	-------------------------	--	--	--	---------------	---

						
2.2 Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд						
2.2.1	“Далд хүчирхийллийг ил болгоё” аяныг үргэлжлүүлэн зохион байгуулах	Жилдээ	Нийгмийн ажилтан Г.Мөнхзаяа	Сумын хамтарсан баг, Сумын ГХУСАЗСЗ	Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, бага насны хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх	Сумын цагдаагийн хэсэг, ЕБС-ийн багштай хамтран эргүүл шалгалтын ажлыг 2 удаа зохион байгуулж зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч ажилласан. Архины хамааралтай 2 гэр бүлийн 5 хүүхдийн мөнгийг захиран зарцуулах эрхийг түр зогсоож хяналтдаа авч ажиллаж байна. Архины хамааралтай 1 иргэнийг сэтгэц наркологийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж сургалтад хамруулсан. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын тухай хуулийн сургалтыг 2 удаа зохион байгуулж 112 эцэг эх асран хамгаалагч хамрагдсан.
2.2.2	Эрсдэлт гэр бүл, хүүхдийн нөхцөл байдлыг үнэлэх төлөвлөгөө гарган ажиллах	Жилдээ	Сумын хамтарсан баг	Цагдаагийн хэсэг, ЗДТГ, ЭМТ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй өрхийн эрсдэл буурсан байна.	Өмнөх оны эрсдэлийн программд бүртгэлтэй 10 хүүхдийн бүртгэлд тодотгол хийж энэ онд 5 хүүхдийг мэдээллийн санд оруулан нөхцөл байдлын үнэлгээ хийж төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Нөхцөл байдлын үнэлгээгээр дэмжлэг туслалцаа шаардлагатай 8 гэр бүлийн гишүүдэд эрүүл

						мэнд, сэтгэл зүй, сэтгэл засал нийгмийн халамж үйлчилгээг хүргэж ажилласан.
2.3 Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд						
2.3. 1	“Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	Жилдээ	Сумын ГХУСАЗСЗ	Цагдаагийн хэсэг, Байгаль орчны хэсэг	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн гаралт буурна.	Сумын ГХУСАЗСЗ-ын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн №11 удирдамжийн дагуу 2025 оны 03 дугаар сарын 10-22-ны хооронд сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүд болон ЗДТГ-ын байгаль орчны хэсэгтэй хамтран Дулаан-Уул багийн иргэдэд байгаль орчин, ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, болзошгүй гал түймрийн аюулаас амь бие эд хөрөнгөө хамгаалах талаар санамж анхааруулгыг нийт 320 өрхөд хүргэн ажилласан. “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд эргүүл хяналт шалгалтыг 10 удаа зохион байгуулж ил задгай гал түлсэн 2 зөрчил илрүүлж зөрчлийг арилгуулсан. Мөн нийтийг хамарсан хог цэвэрлэгээний ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 02-ныг хүртэл зохион байгуулж 218 га талбайн 316 шоо метр хог хаягдлыг цэвэрлүүлсэн. Уг арга хэмжээнд 9 байгууллагын 360 албан хаагч оролцсон. Хуурайшилтын улиралд ахуйн хог шатааснаас гал алдаж түймэр тавьсан 2 иргэнд зөрчлийн тухай хуулиар торгуулийн арга хэмжээг авсан. Эргүүл хяналт шалгалтын явцад зориулалтын бус газарт хог асгахыг завдсан 4 зөрчил илрүүлж зөрчлийг арилгуулан ажилласан.

						
--	--	--	--	--	--	--

2.4 Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

<p>2.4. 1</p>	<p>“Хөршийн холбоо”-г Идэвхжүүлье Хөгжүүлье нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>Жилдээ</p>	<p>Сумын ГХУСАЗСЗ</p>	<p>ГХУСАЗСЗ-ийн гишүүд Цагдаагийн хэсэг, БИНХ, Багийн ажлын алба Нийгмийн ажилтан</p>	<p>Сумын хэмжээнд хулгайн болон гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчил багасаж, иргэдийн хуулийн мэдлэг дээшилсэн байна.</p>	<p>Сумын ГХУСАЗСЗ-ын даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 08 удирдамжийн дагуу сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, сумын иргэдэд амралт зугаалгын цаг ирж байгаатай холбогдуулан хулгайн гэмт хэрэг болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар тараах материал болон зурагт танилцуулгыг тараах ажлыг 06 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд хийсэн.</p>  
-------------------	--	---------------	-----------------------	---	--	---

						
2.4. 2	“Мал мах 2025” арга хэмжээг зохион байгуулах	I, IV улиралд	Цагдаагийн хэсэг	ХААТ	Мал хулгайлах гэмт хэргийн гаралт буурч, хяналт сайжирна.	<p>“Мал мах 2025” нэгдсэн арга хэмжээг 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл Жаргалант сумын замын байнгын хяналтын постод 10 алба хаагч 24 цагаар ээлжлэн үүрэг гүйцэтгэсэн. Үүрэг гүйцэтгэх хугацаанд 5000-6000 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийж зөрчилтэй 340 тээврийн хэрэгслийг илрүүлэн бэлэн бусын төхөөрөмжөөр 2,470.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.</p> 



2.5 Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд



2.5. 1	“Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2025” аяныг зохион байгуулах	Жилдээ	Сумын ГХУСАЗСЗ	Цагдаагийн хэсэг	Замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг буурна.	Сумын ГХУСАЗСЗ-ийн даргын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн №08 удирдамжийн дагуу “Дүрмээ Мөрдье” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Цагдаагийн байгууллагаас зохион байгуулсан “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2025”, “Шугаман эргүүл-цагийн менежмент” арга хэмжээнүүдийн хүрээнд Орхон аймгийн цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагтай хамтран 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл улсын чанартай А1001 дугаартай авто зам буюу Их хөшөөтийн даваанаас 3-н замын уулзварын хооронд хөдөлгөөнт эргүүлээр 4 алба хаагч 2 ээлжээр 24 цагийн үүрэг гүйцэтгэн ажилласан. Ажиллах хугацаанд нийт 16459 тээврийн хэрэгсэл, зөрчилтэй 2626 иргэнийг шалгаж зөвлөмж зөвлөгөө өгч 2626 хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг болон бусад
-----------	---	--------	----------------	------------------	--	---

зөрчил илрүүлж зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлж 2626 зөрчил гаргасан иргэнд холбогдох хуулийн дагуу 54.987.000 төгрөгийн арга хэмжээ авч согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 9 иргэнийг илрүүлэн 1 жилээр эрхийг нь хасах саналтай Орхон аймгийн анхан шатны шүүхэд шилжүүлж зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж ажиллаа.



						
2.5. 2	Жил бүр Орхон аймгийн цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулагддаг “Ногоон гэрэл, цагаан шугам” тэмцээнд оролцох	V сард	3-р цэцэрлэг ХХБ	Багш, ажилчид, Эцэг эх, асран хамгаалагчид	Хүүхдүүдийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дээшилнэ.	<p>Сумын ГХУСАЗСЗ-ийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн №06 удирдамжийн дагуу Орхон аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдүүдийн дунд жил бүр уламжлал болгон зохион явагддаг “Ногоон гэрэл, цагаан шугам” тэмцээнд 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 3 дугаар цэцэрлэгийн 10 хүүхэд, 2 багш, 4 эцэг эх, асран хамгаалагч нар амжилттай оролцсон.</p> 

						
2.5. 3	Сумын авто замын тэмдэг, тэмдэглэгээ, нөхөөс, хүйтэн асфальт засвар үйлчилгээг шинэчлэх, засварлах.	Жилдээ	ГХ,ЗУСАЗС Зөвлөл, цагдаагийн хэсэг	ГХ,ЗУСАЗС Зөвлөл,	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх хамгаалагдан	Сумын авто замын тэмдэг, тэмдэглэгээг хийлгэхээр сумын 2025 оны аваарын зардалд тусгагдаж одоогийн байдлаар гэрээг хийж ажиллаж байна.
2.6 Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд						
2.6. 1	Цахимаар залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	Багийн ажлын алба	Багийн ажлын алба	Энэ төрлийн гэмт хэрэг тодорхой хувиар буурсан байна.	2025 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр Орхон аймгийн Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн Л.Содбилэгтэй хамтран сумын иргэдэд цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг оруулсан. Сургалтад нийт 60 иргэн хамрагдсан. Мөн Улсын тэргүүний Жаргалант сум пэйж хаяг болон 3 багийн цахим групп болон групп чаатанд цахим залилангаас урьдчилан сэргийлэх мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна.

						 
--	--	--	--	--	--	--



2.7 Бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

2.7. 1	“Цагаан шонхор бүлгэм”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, туршлага	IV сард	ЕБС	ГХУСАЗСЗ	“Цагаан шонхор бүлгэм”-ийн үйл ажиллагаа идэвхэжсэн байна.	2025 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр Ерөнхий боловсролын сургуулийн “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн 13 гишүүн, анги удирдсан багш болон сургуулийн нийгмийн ажилтан нарын хамтаар Орхон аймгийн ерөнхий
-----------	---	---------	-----	----------	--	--

	судлах					боловсролын сургуулийн 17-р сургуулийн өсвөрийн сэргийлэгч “Дөл” бүлгэмийн үйл ажиллагаатай танилцсан.
2.7. 2	Үндсэн хууль болон бусад хуулийг таниулж, сурталчлах ажлыг зохион байгуулах	Жилдээ	Сумын ГХУСАЗСЗ	ЗДТГ	Иргэдийн хуулийн мэдлэг дээшилнэ.	<p>Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01 удирдамжийн дагуу Монгол Улсын Үндсэн Хууль батлагдсаны 33 жилийн ойн өдөрт зориулж залуу бөхчүүдийн дунд Үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулсан.</p>  <p>The top photograph shows a wrestling match in progress on a green mat. A banner in the background reads 'ҮНДЭСНИЙ БӨХНИЙ БАРИЛДАМ' (National Wrestling Championship). The bottom photograph shows an award ceremony where a young wrestler in blue and red gear is receiving a certificate from a man in a suit, with another man in traditional blue clothing standing nearby.</p>

						
2.7.3	Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, гудамж талбай, бүтээн байгуулалтын аюулгүй байдлыг хангуулах	Жилдээ	Сумын ГХУСАЗСЗ	БОХ, Ногоон байгууламжийн ажилтан Багийн ажлын алба Холбогдох бусад байгууллага	Нийтийн эзэмшлийн аюулгүй байдал хангагдана.	Жаргалант сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, ЗДТГ-ын байгаль орчны хэсэгтэй хамтран Дулаан-Уул багийн иргэдэд байгаль орчны хууль тогтоомж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, болзошгүй гал түймрийн аюулаас амь бие эд хөрөнгөө хамгаалах талаар санамж анхааруулгыг нийт 320 өрхөд хүргэн ажилласан. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд эргүүл хяналт шалгалтыг 10 удаа зохион байгуулж ил задгай гал түлсэн 2 зөрчил илрүүлж зөрчлийг арилгуулж, Жаргалант багийн нутаг дэвсгэрт байрлах нийтийн эзэмшлийн газрын эд хөрөнгийг сүйтгэх зөрчлийг Жаргалант багийн ажлын алба, цагдаагийн хэсэгтэй хамтран эзнийг олж тогтоон арга хэмжээг авч ажилласан байна.


						 
2.7. 4	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумын камержуулалтыг нэмэгдүүлэх	Жилдээ	Сумын ГХУСАЗСЗ	Холбогдох бусад байгууллага	Гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдэж, гаралт буурна.	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумын хэмжээнд 2025 онд аваарын зардлаар нийт 10 камерыг суурилуулсан. Улаантолгой багийн цэцэрлэгт хүрээлэнд 4 камер, Улаантолгой багийн ажлын байранд 1, Улаантолгой багийн хаягийн самбар 3-н замын уулзвар дээр 1 камер, 30-н айлын гадна зогсоол, суваргатай

						<p>толгойн алхалтын зам руу харсан 2 камер, Дулааны станцад 1 камер, Агро паркийн хашаанд дээр 1 камер тус тус хийгдсэн.</p>  
2.7.5	Гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох ажлыг хурдан шуурхай гүйцэтгүүлэх зорилгоор цагдаагийн хэсэгт автомашин	Жилдээ	Сумын ГХУСАЗСЗ ЗДТГ	Цагдаагийн хэсэг	Гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох ажил сайжирсан байна.	Сумын хөрөнгө оруулалтын зардлаар цагдаагийн хэсэгт 48,800,000 сая төгрөгөөр Хасу Бизнес ХХК-тай гэрээ байгуулж сумын Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/112 дугаар захирамжаар ажлын хэсэг машиныг хүлээн авч цагдаагийн хэсэгт хүлээлгэн өгсөн.

	нийлүүлэх					
ГУРАВ. СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД						
3.1	“СОЁЛ ТАНААС ЭХЭЛНЭ” , нөлөөллийн ажил хийх	Жилдэ э	Сумын ГХУСАЗСЗ	Холбогдох бусад байгууллага	Сумын хэмжээнд төрийн байгууллагууды н идэвх оролцоог дээшилсэн байна.	Сумын ГХУСАЗСЗ-ийн даргын 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн №09 удирдамжийн дагуу “Соёл танаас эхэлнэ” нөлөөллийн ажлыг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр сумын хэмжээнд ой хээрийн болон объектын галын осол, аюул өмнөх онуудаас их гарч байгаатай холбогдуулан сумын хэмжээнд галын аюулгүй байдлын хяналт шалгалтыг урьдчилсан байдлаар явуулахад айл өрхүүд болон аж ахуйн нэгжүүдэд “Соёл танаас эхэлнэ” нөлөөллийн арга хэмжээгээр аймгийн онцгой байдлын газартай хамтран цахилгааны утас, монтаж холболт болон урьдчилан сэргийлэх талаар үзүүлэх сургалтыг зохион байгуулсан. Нөлөөллийн арга хэмжээний хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн №09.2 удирдамжийн дагуу 2025 оны 11 дүгээр

сарын 27-ны өдөр “Гэр бүлийн гишүүдийн сэтгэл хөдлөлийн дасгалжуулалтын төв” ТББ-тай хамтран төрийн албан хаагчдын хувь хүний сэтгэл зүйн тэнцвэр, гэр бүлийн харилцааны үүрэг, хариуцлагыг зөв ойлгуулах замаар ажил амьдралын зохистой тэнцвэрийг бүрдүүлж, байгууллагын бүтээмж, хамт олны эерэг уур амьсгалыг сайжруулснаар гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын төрийн албан хаагчдад “Сэтгэл эдгэрдэг” “Гэр бүлийн үүрэг” сэдэвт сургалтыг сэтгэл зүйч Алтанцэцэг, Бямбасүрэн нартай хамтран зохион байгуулсан. Уг сургалтад төрийн 6 байгууллагын 36 албан хаагч хамрагдсан.



						
3.2	“БҮГД АНХААРЪЯ” сарын аян	Жилдээ	3-р цэцэрлэг ХХБ	Багш, ажилчид, Эцэг эх, Хүүхдүүд		<p>Сумын ГХУСАЗСЗ-ийн дарга, 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч нарын 2025 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн төлөвлөгөөний дагуу “Бүгд анхааръя” аяныг:</p> <ul style="list-style-type: none"> • Багш сурагчдын хамтарсан бичлэг • Халтиргаа гулгаанаас сэргийлье • Хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг таниулан сурталчлах • Ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлье • Замын хөдөлгөөнд соёлтой оролцъё • Далд хүчирхийллээс урьдчилан сэргийлье • Хүүхэд хамгааллын самбараар тогтмол мэдээлэл өгөх гэсэн 7 чиглэлийн дагуу сумын Төрийн өмчийн байгууллага иргэдийн дунд амжилттай зохион байгуулсан. Аяны гол зорилго нь бидний ирээдүй болсон ХҮҮХЭДҮҮДЭЭ элдэв эрсдэл,


болзошгүй аюулд өртөхөөс хамгаалж хүн нэг бүрийн оролцоо чухал гэдгийг харуулж, анхааруулахыг зорисон. Аяны хүрээнд нийт 487 иргэн, төрийн өмчийн 5 байгууллагын 87 албан хаагчдад хүрч, 5 хүүхдийг эрсдэлд өртөхөөс хамгаалан ажиллаа.



						
3.3	Бага насны хүүхдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж эцэг эхчүүдийн дунд хуулийг сурталчлах, хүрээнд “Эрүүл агаар-эм” хэлэлцүүлэг, явган аяллыг зохион байгуулах	Жилдээ	3-р цэцэрлэг	Сумын ГХУСАЗСЗ	Эцэг эхчүүдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	Сумын ГХУСАЗСЗ-ийн дарга болон 3-р цэцэрлэгийн эрхлэгч нарын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хамтран баталсан удирдамжийн дагуу бага насны хүүхдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг эцэг эх, асран хамгаалагч нарт сурталчлах ажлын хүрээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Эрүүл агаар-Эм” сэдэвт явган аяллыг 3 дугаар цэцэрлэгийн эцэг эхчүүдийн дунд 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр 11 Жаргалант багийн морь барианы талбайд үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Тус тэмцээнд 6 бүлгийн нийт 36 эцэг эх, 15 багш ажилчид хамрагдсан бөгөөд 4 төрлийн арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: Тэргүүн байрыг Л.Эрдэнэчимэг багштай “Унага”- Ахлах ”Б” бүлэг, дэд байрыг У.Жигжидмаа багштай, “Хургахан” Ахлах “А” бүлэг, гутгаар байрыг Ж.Бүрэнтөгс багштай “Тугалхан” Бага ”Б” бүлэг, тусгай байрыг

Ч.Агиймаа багштай “Шагай ” “Бэлтгэл” бүлэг тус тус эзлэв.





3.4	Сумын хэмжээнд бүх нийтийн бие тамирыг дэмжиж “Хөдөлгөөнөөр эрүүлжье” аяныг зохион байгуулах	Жилдээ	Бүжгийн багш Н.Энхзаяа	Сумын ГХУСАЗСЗ, СМТ, ЕБС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, цахим орчноос ангид байлгах	<p>Жаргалант сумын ИТХ-н дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга уриалгаар Олон улсын бүжгийн өдрийг угтан иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах, хэвшүүлэх “Бүжгийн флаш моб”-г соёл мэдээллийн төвөөс 2025 оны 04 дүгээр сараас эхлэн 1 сарын турш ахмад үе болон залуу үе гэсэн 2 насны ангиллаар зохион байгуулж олон улсын бүжгийн өдөр буюу 04 дүгээр сарын 29-ны өдөр шилдгүүдээ тодруулан цахимаар сурталчлан ажилсан. Залуу үеэс Жаргалант сумын ЕБС-н 7а, 7б ангиуд шалгарсан бол ахмад үеэс ахмадын хороо шалгарсан.</p> 
-----	--	--------	------------------------	--------------------------	---	--



						
3.5	Ахлах ангийн сурагчдад “Эх оронч үзэл-Иргэн бүрээс” нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Жилдээ	Сумын ГХУСАЗСЗ	Холбогдох бусад байгууллага	Ахлах ангийн сурагчдад Эх оронч үзлийг төлөвшүүлсэн байна.	Цаг үеийн нөхцөл байдлаас болж хэрэгжээгүй.
ДӨРӨВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЛААР						
4.1	Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй зорилтот бүлгийн өрхөөр орж хяналт тавих	Жилдээ	Багийн ажлын алба	Цагдаагийн хэсэг Сумын нийгмийн ажилтан	Хүүхэд болон гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдал хангагдана.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй болон эрсдэлт нөхцөлд байгаа 12 өрхийн 21 хүүхдэд гэрийн эргүүл шалгалтыг сар бүр цагдаагийн хэсэг, сургуулийн нийгмийн ажилтантай хамтран 6 удаагийн эргүүл шалгалт хийж ажилласан байна. Эргүүл шалгалтын хүрээнд: <ul style="list-style-type: none"> • Сэтгэл заслын үйлчилгээнд-5 хүүхэд • Сэтгэл зүйн зөвлөгөө-32 хүүхэд • Эрүүл мэндийн үйлчилгээ-6 хүүхдэд үзүүлж ажилласан.

--	--	--	--	--	--




4.2	Гэр хорооллын айл, өрхүүдэд галын аюулаас урьдчилан сэргийлэх	I, IV-р улиралд	Сумын ГХУСАЗСЗ	Онцгой байдлын газар	Галын осол, аюулаас урьдчилан сэргийлж, иргэдэд мэдлэг,	<p>Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөт ажлын дагуу сумын хэмжээнд гал түймрийн эрсдэл их гарч байгаатай холбогдуулан салбар зөвлөлийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 04 дугаар удирдамжийн дагуу аймгийн онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах 56 дугаар ангийн 2,3,4 дүгээр салааны 36 албан хаагчийн бүхэлдэхүүн болон сумын ЗДТГ-ын холбогдох албан хаагчид хамтран 5 чиглэлд ажилласан. Албан байгууллага, айл өрхүүдийн өвс тэжээлийн хадгалалт, галлагаа болон зуух яндан, хийн баллоны ашиглалт, цахилгаан монтажийн аюулгүй байдал гэх мэт асуудлаар хяналт шалгалтын хийж, зөвлөмж өгч ажиллаа.</p> 
-----	---	-----------------	----------------	----------------------	---	---

						 
4.3	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн	Улирал бүр	Сумын ГХУСАЗСЗ	Цагдаагийн хэсэг	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль хэрэгжсэн	Орхон аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 25-ны А/700 дугаар захирамжийн дагуу сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн даргын 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн №10 удирдамжийн дагуу сумын цагдаагийн хэсэгтэй хамтран согтууруулах ундааг



	хэрэгжилтэд хяналт шалгалтыг зохион байгуулах				байна.	<p>худалдан борлуулах, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалтыг 2025 оны 08 дугаар сарын 31-ээс 09 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэл хийсэн.</p>  
4.4	Соёлын үл хөдлөх дурсгалт газрын бүрэн бүтэн байдалд	VI, X сард	ОНСТ Б.Нэмэхням	ИТХ, СМТ, гэрээт харуул иргэд	Гэрээт харуулуудтай уулзаж зөвлөгөө зөвлөмж өгч	Сумын ГХУСАЗСЗ-ийн дарга, СМТ-ын дарга нарын хамтран баталсан удирдамжийн дагуу 2025 оны 04 дүгээр сарын 28-аас 05 дугаар сарын 30, 2025 оны 11 дүгээр сарын 17-21-ны

	хяналт тавих				<p>санал бодлыг нь сонсож цаашид хамтран ажиллах тал дээр үр дүнтэй ажлуудыг төлөвлөн дэс дараатай явуулах.</p>	<p>өдрүүдэд Жаргалант сумын Дулаан уул багийн нутаг дэвсгэрт байрлах Хүннү гүрний хожуу үе Сянби эхэн үед Айргийн гозгорын 97 булш хиргисүүр болон бусад 200 орчим булш хиргисүүрийн бүрэн бүтэн байдалд анхаарал тавьж эргүүл хийж 18 гэрээт харуулуудтай уулзлаа. Эрсдэлгүй бүс болгох тал дээр 4 гэрээт харуулуудад зөвлөмж зөвлөгөө өгч ажиллалаа.</p>  
--	--------------	--	--	--	---	---



						
4.6	“Сургуулийн цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих	Жилийн турш	Сургуулийн нийт эцэг эхчүүд	ТБХХА , Сумын хүүхэд хүмүүжлийн эерэг аргын сургагч багш нар	Эрсдэл буурч, хүүхдийн аюулгүй байдал хангагдана. Замын хөдөлгөөний осол гэмтлээс урьдчилан сэргийлнэ.	Орхон аймгийн Жаргалант сумын ЕБС-ийн “Сургуулийн цагдаа” хөтөлбөрийг сургууль дээрээ хэрэгжүүлэн ажиллаа. Уг ажлын хүрээнд Орхон аймгийн Засаг даргын А/633 дугаар захирамжийн дагуу Жаргалант ЕБС-ийн “Сургуулийн цагдаа” эргүүлийн ажиллах журам, хуваарь гарган өдөрт 2 цэг дээр 4 эцэг эх асран хамгаалагч нар сурагчдын аюулгүй байдалд хяналт тавин, эргүүл хийж эцэг эхчүүд дэвтэрт тэмдэглэл хөтлөн анги

удирдсан багш нар сургуулийн группээр сургуулийн цагдаа хийсэн тайланг оруулж мэдээллээр ханган ажилласан. Хүүхэд хамгааллын хууль , БСШУС сайдын /2018 оны А/239/ журам , ЗХАБТХ - ийн 13.2.7 заалтыг тус тус үндэслэн 1-5 ангид сурагчдыг зам тээврийн осол болон бусад болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зорилгоор “Гараас гарт “ хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна. Эцэг эх асран хамгаалагч нар АУБ-д хүлээлгэн өгч, авч гарын үсэг зурж хэвшсэн. Гэр нь ойр болон ах эгч нь ирж авдаг 4-5 ангийн сурагчдын асран хамгаалагч нар хүсэлт бичиж өгдөг. 2024-2025 оны хичээлийн жилд СУРГУУЛИЙН ЦАГДАА болон ГАРААС ГАРТ хөтөлбөрт нийт бага ангийн 217 суралцагч хамрагдан амжилттай хэрэгжиж гарсан зөрчилгүй ажилласан.



						<p>Т. Оюун-Эрдэнэ 4-р сарын 23 · 🌐</p> <p>2025 оны 04-р сарын 14-18 хооронд 1а ангийн эцэг эр, асран хамгаалагч нар СУРГУУЛИЙН ЦАГДАА-гийн үүрэг гүйцэтгэлээ. Энэ хугацаанд гарсан зөрчилгүй тайван байлаа. Хариуцлагатайгаар үүргээ биелүүлсэн эцэг эх, асран хамгаалагч нартаа баярлалаа.</p> 
4.7	Дотуур байрны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Жилдээ	Сумын ГХУСАЗСЗ	Цагдаагийн хэсэг, Холбогдох бусад байгууллага	Дотуур байранд учирч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.	<p>Сумын ГХУСАЗСЗ-ийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн №14 дугаар удирдамжийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр ГХУСАЗСЗ-ийн гишүүд сумын дотуур байрны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж заавар, зөвлөмжийг өгч ажилсан.</p> 

						
4.8	Бусад чиглэлээр хянал шалгалт хийх	Тухай бүр	Сумын ГХУСАЗСЗ	Холбогдох бусад байгууллага	Илэрсэн зөрчил дутагдал арилсан байна.	Сумын ГХУСАЗСЗ-ийн даргын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн №08 удирдамжийн дагуу “Дүрмээ Мөрдье” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Цагдаагийн байгууллагаас зохион байгуулсан “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2025”, “Шугаман эргүүл-цагийн менежмент” арга хэмжээнүүдийн хүрээнд Орхон аймгийн цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагтай хамтран 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл улсын чанартай А1001 дугаартай авто зам буюу Их хөшөөтийн даваанаас 3-н замын уулзварын хооронд хөдөлгөөнт эргүүлээр 4 алба хаагч 2 ээлжээр 24 цагийн үүрэг гүйцэтгэн ажилласан.


						 
--	--	--	--	--	--	--

ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС АЖЛУУД

1	<p>Орхон аймгийн Цагдаагийн газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 42/5125 тоот албан бичгийн дагуу Жаргалант сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх А-1001 зам дагуу нутаглах малчдад урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт хийж. Бод малын хүзүүнд цацруулагчтай хүзүүвч зүүх ажил, арга хэмжээг зохион байгууллаа</p>	
---	--	--

		
2	<p>2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр малын хулгай болон бусад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Хөршийн холбоо” арга хэмжээг зохион байгуулав. Энэхүү арга хэмжээний хүрээнд эргүүл шалгалт хийх иргэний хариуцлагын хүрээнд сумын ГХУСАЗСЗ, сумын Цагдаагийн хэсэг, Жаргалант сумын 3 багийн 61 иргэнтэй гурвалсан гэрээг байгуулав. Мөн 11 дүгээр сарын 17-ны өдөр Орхон аймгийн Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан Чиглэлийн ахлах мэргэжилтэйн Л.Содбилэг, эргүүл шалгалтыг ахлан ажиллаж</p>	

байгаа Ж.Эрдэнэ-Очир 61 иргэнд сургалт оров.



3

Сумын ГХУСАЗСЗ-ийн дарга, Ерөнхий боловсролын сургуулийн захирлын хамтран 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр баталсан “Дээрэлхэлт дэргэрэх ёсгүй” аяны төлөвлөгөөний дагуу нийт сурагчдаас үе тэнгийн дээрэлхэлт гаргаж болзошгүй болон дээрэлхэлтэд өртөж болзошгүй сурагчдын тандалт судалгаанд 276 сурагч хамрагдаж, 42 сурагчдад нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн. Мөн гэмт хэрэгт орж болзошгүй сурагчдын суурь судалгаа болон 6-9 дүгээр ангийн нийт сурагчдаас “Сэтгэл хөдлөлийн зан үйлийг тодорхойлох” судалгааг авч үр дүнг нэгтгэж АУБ нарт танилцуулж, цаашид ажиллах бүлгийн зөвлөгөө, ганцаарчилсан зөвлөгөө болон сургалтын ажлуудыг төлөвлөн ажиллаж байна. Тус аяны хүрээнд “Гадуурхалтын эсрэг зогсьё” рийлийн бичлэгийн уралдааныг 6-



12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд дунд болон ахлах ангийн нийт 10 бүлгийн 120 сурагчид оролцсон бөгөөд ангиуд рийл бичлэгийг сургуулийн цахим хуудсанд оруулахаас гадна аяны хүрээнд хийгдэх бусад арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.



Тайлан гаргасан:

ИТХ-ын мэргэжилтэн

Ч.Батчимэг

Хянасан:

ИТХ-ын дарга бөгөөд
сумын ГХУСАЗСЗ-ийн дарга

Ш.Билгүүнбаатар